



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/33

Амардалай

Бэлчээр чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2, Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны А/32 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн ургамал сүйтгэгч үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх ажлыг орон нутагт зохион байгуулж байгаатай холбогдуулан бэлчээрийг бэлдмэл цацсан өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд чөлөөлсүгэй.

2.Бэлдмэл цацаж, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажил зохион байгуулсан талбайгаас мал сүргээ эрүүл нутаг, бэлчээрт гарган бэлчээр чөлөөлөхийг малчдад үүрэг болгосугай.

3.Бэлчээр чөлөөлөх хугацаанд хөдөлмөр хамгаалал, хүн малын эрүүл ахуй шаардлагыг хангах талаар мэдээллийг малчдад хүргэх, зохион байгуулж хамтран ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ



432401065